

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ИЙН 2015 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

I. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:

Хаяг: Дорноговь аймаг, Замын үүд сум, 1-р баг 10-р хэсэг, Э-Транс ложистикс ХК-ийн байр

Утас: 02524543813, 99117636, 95956390

Электрон хаяг: www.etr.mn

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл

Компанийн нэр: “Э-Транс Ложистикс” ХК

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо: 2011.12.06

Улсын бүртгэлийн дугаар: 0610001001

Регистерийн дугаар: 3309665

Үйл ажиллагааны чиглэл: Ачаа шилжүүлэн ачих

Хувьцаа эзэмшигчдийн тоо:

“Э-Транс” ХХК нь 2007 оноос ачаа шилжүүлэн ачих төсөл хэрэгжүүлж эхлэн 2009 онд ашиглалтанд оруулсан бөгөөд энэхүү үйл ажиллагаагаа компаниас тусгаарлан “Э-Транс Ложистикс” ХХК-нд шилжүүлсэнээр 2010 оноос одоог хүртэл үйл ажиллагаагаа тасралтгүй амжилттай явуулж ирлээ.

Тус компани нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р баг, 10-р хэсэгт буюу Хятад улсаас манай улстай хиллэж байгаа хамгийн том боомт Эрээн хотоос 10 километр, улсын хилийн хаалтаас 100 метрт байрладаг ба энэ нь үйлчлүүлэгч байгууллага, иргэнд хамгийн тохиромжтой байрлалд тооцогддог.

Зураг 1. Компанийн байршил



Манай компанийн үндсэн үйл ажиллагаа нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ачаа, барааг төмөр замаар тээвэрлүүлэхээр хүсэлт ирүүлсний дагуу УБТЗ-ын харьяа Замын-Үүд өртөөнд тээвэрлүүлэх ачааны төрөл байдлаас шалтгаалан тухайн төрлийн “ачааны” вагоныг захиалан өөрийн салбар замаас тэдний ачаа, барааг зохих журмын дагуу ачиж хүлээн авагчид нь илгээх явдал юм. Үүнээс гадна тус компани нь гаалийн баталгаат агуулах, гаалийн нэг цэгийн үйлчилгээ, авто замаар ачаа, бараа тээвэрлэх үйл ажиллагаа зэргээр үйлчилгээнийхээ нэр төрлийг олшируулан цаашид олон улсын ложистикийн үйл ажиллагаа эрхлэх чиглэл барьж ажиллаж байна.

Э-Транс Ложистикс ХХК нь 2012 оны 4-р сард хөрөнгийн бирж дээр өөрийн хувьцаагаа арилжаалан хувьцаат компанийн статустай болж техник технологи, материал техник, ажиллах хүчээ улам өргөжүүлэх ажлын эхлэлийг тавьсан.

Зураг 2. Гаалийн нэг цэгийн үйлчилгээ бүхий оффис



Гаалийн нэг цэгийн үйлчилгээний танхим бүхий оффисын барилгыг 2012 онд барьж байгуулан улсын комисст хүлээлгэн өгсөн бөгөөд одоо тус байгууламжийн 1-р давхарт гаалийн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх танхим / үүнд: гаалийн ахлах болон улсын байцаагч, хилийн мэргэжлийн хяналтын байцаагч нарын ажил үүргээ гүйцэтгэх өрөө тасалгаанууд, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарын ажлын байр, банкууд, компанийн ачаа тээврийн алба болон цайны газар байрлана /, 2-р давхарт компанийн захиргаа удирдлагын өрөө тасалгаанууд, 3-р давхарт компанийн ажилчдын 9 айлын байр, зочид төлөөлөгчдийг байрлуулах 3 өрөө, подвалийн

давхарт ажилчдын хувцас солих өрөө, халуун хүйтэн ус, агуулах, фитнесийн өрөө, автомашины гарааш тус тус байрлаж байна.

1. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:

Манай ачаа шилжүүлэн ачих терминал нь импортын барааг тээврийн хэрэгслээс хөдлөх бүрэлдэхүүнд, экспортын барааг хөдлөх бүрэлдэхүүнээс тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачих үйлчилгээг үзүүлж байна. Эрээнээс бараа бүтээгдэхүүн оруулж ирж буй хэрэглэгчид гаалийн хяналтын бүсэд ачаа барааны бүрдүүлэлт хийж, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт өөр бусад хүссэн газар луугаа илгээж, хүлээн авах боломжтой нэг цэгийн үйлчилгээний төв юм.

Замын-Үүд боомтоос БНХАУ руу гарах хилийн хаалгаас 100 метрийн зайд байрладаг ба энэ нь хэрэглэгчдэд маш тохиромжтой байрлал юм. Ачаа ачсан хүнд даацын машинууд Төмөр замын шилжүүлэн ачих өртөө /ШАӨ/-д хүрэхэд тэдний цаг хугацаа, шатахууны зардлыг нэмэгдүүлдэг. Иймээс манай хяналтын бүс нь хэрэглэгчдэд олон төрлийн үйлчилгээг нэг дор хүргэж, шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангагдсан шилжүүлэн ачих терминал юм.

Дараах хүчин зүйлс нь Терминалыг үр ашигтай ажиллахад нөлөөлж байна.

- Хэрэглэгчдэд хамгийн тохиромжтой байрлал
- Θндөр ур чадвартай менежмент
- Хятадын талтай хамтран Эрээнээс Замын-Үүдэд эсвэл Улаанбаатарт хүрэх тээврийн үйлчилгээгээр хангах
- Хамтран ажиллах тааламжтай нөхцөл гэх мэт олон хүчин зүйлс нь үр ашигтай ажиллах, зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлж байна.
- Ачааг шилжүүлэн ачих ачилтыг хялбарчлах үүднээс туузан дамжуурга, автокран, погрузчик гэх мэт зарим механикуулалтыг нэвтрүүлсэн.
- Гаалийн баталгаат агуулахын үйлчилгээ
- 24-н цагийн харуул хамгаалалт, IP- камериийн систем сууринуулж ачаа барааг бүрэн хянах боломжтой.


Бид цаашид тээвэр ложистикийг бүрэн утгаар нь хөгжүүлэн, олон улсыг холбосон тэргүүлэх зэрэглэлийн терминалыг Монголд бий болгох, Ачаа шилжүүлэн ачих цаг хугацаа, ажиллах хүч хэмнэх, үйл ажиллагааг хялбарчлах өндөр бүтээмжтэй техник технологийг нэвтрүүлэх, Вагонд ачих ачааны нэр төрлийг олшуулан, өөрийн нөөц бололцоог ашиглан бүхий л төрлийн вагонд ачилт хийж, вагоны цаг ашиглалтыг багасгах, сул зогсолт гаргахгүй байх үндсэн үйл ажиллагааг сайжруулах, хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

2. Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь

Тус компанийн ажил үйлчилгээний гол хэлбэр нь ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагаа юм. Манай ачаа шилжүүлэн ачих терминал одоогийн байдлаар Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулж байгаа бусад терминалуудаас газар нутгийн байрлалаараа ихээхэн давуу талтай. Ачаа шилжүүлэн ачих терминал нь бүрэн хүчин чадлаараа ажиллавал 1 өдөрт 34 вагон сард 1012 вагон нийт жилд 800,000 тн ачааг шилжүүлэн боломжтой. Манай компани нь төмөр замын ачаа тээврийн үйл ажиллагааг улам өргөжүүлэх, ачаа барааны нэр төрлийг олшуулах зорилго тавин

ажиллаж байгаа бөгөөд зарим төрлийн тээврийн үйл ажиллагааг өөрийн хүч бололцоонд түшиглэн зохион байгуулан ажиллаж байна.

Зураг 3. Шилжүүлэн ачилт хийгдэж байгаа нь



Замын –Үүд суманд ачаа шилжүүлэн ачих терминалийн үйлчилгээ явуулж буй байгууллагуудын мэдээлэл:

Терминал	Хилийн хаалганаас зайд	Үйл ажиллагааны чиглэл	Онцлог
“Э-Транс Ложистикс” ХК	100м	Монголын өргөн царигын вагон болон авто машин хооронд ачаа шилжүүлэн ачдаг.	- Нэг цэгийн үйлчилгээ - Барилгын материал болон төрөл бүрийн ачаа шилжүүлэн ачдаг.
Тэмэр замын харьяа шилжүүлэн ачих өртөө I	6 км	Хятадын төмөр замын нарийн царигийн вагон, Монголын төмөр замын өргөн царигын вагоны хооронд хүнд даацын ачаа шилжүүлэн ачих, авто машин вагон хооронд хялбар муудах ачаа, чингэлэг шилжүүлэн ачдаг.	- Нэг цэгийн үйлчилгээ - Хүнд даацын ачаа шилжүүлэн ачдаг.

Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө II	4км	Нарийн царигаас өргөн цариг руу болон автомшинаас вагон луу чингэлэг шилжүүлэн ачдаг.	- Нэг цэгийн үйлчилгээ - Эрээний агент байрладаг. - Чингэлэг шилжүүлэн ачдаг.
Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө III	11 км	Автомшинаас вагон руу цемент шилжүүлэн ачдаг.	- Барилгын материал болон өргөн хэрэглээний бараа шилжүүлэн ачдаг. - Бусад үйлчилгээ байхгүй

3. Компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл

Бид ачаа шилжүүлэн ачих цаг хугацаа, ажиллах хүч хэмнэх, үйл ажиллагааг хялбарчлах өндөр бүтээмжтэй техник технологийг нэвтрүүлэх, вагонд ачих ачааны нэр төрлийг олшруулан, өөрийн нөөц бололцоог ашиглан бүхий л төрлийн вагонд ачилт хийж, вагоны цаг ашиглалтыг багасгах, сул зогсолт гаргахгүй байх үндсэн үйл ажиллагааг сайжруулах, хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэхээр зорин байна.

Хүснэгт 3. Ачилтыг ачааны төрлөөр нь ялгаж харуулсан нь:

Сар	Цемент	Барилгын төрөл бүрийн материал	Кран	Модон материал	Бусад	Нийт
1	34	36	2	17	11	100
2	22	27		7	20	76
3	346	57	3	19	14	439
4	804	98	9	27	17	955
5	811	77	24	25	9	946
6	786	76	13	24	22	921
7	822	117	14	16	20	989
8	860	115	20	18	49	1062
9	804	98		15	29	946
10	525	82	6	19	15	647
11	70	45		9	30	154
12	43	35	2	11	43	134
Дүн	5927	863	93	207	279	7369

Төмөр замаар ачаа тээвэрлэх үйл явц нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын худалдан авах чадвараас ихээхэн шалтгаалдаг бөгөөд сүүлийн жилүүдэд улс орны эдийн засгийн хэлбэлзэл, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын худалдан авах чадвар, бараа эргэлт багассан зэргээс шалтгаалан компанийн үйл ажиллагаа тодорхой хэмжээнд багассан байдал өмнөх жилүүдийн үйл ажиллагаанд судалгаа хийж үзэхэд харагддаг.


4. Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл

Компанийн зүгээс үйлчлүүлэгчдийг татах, хурдан шуурхай үйлчилгээг хүргэх, үйлчлүүлэхэд таатай орчинг бүрдүүлэх, үйл ажиллагаагаа сурталчилан танилуулах зэрэг олон нийтийг хамарсан олон төрлийн уян хатан бодлого, сурталчилгаа явуулсан ба хамт олны зүгээс ч энэхүү бодлогыг дэмжин баг хамт олон болж гар нийлж ажилласны хүчинд 2015 онд өөрийн салбар замаас ачигдсан вагоны тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2 дахин өссөн байгааг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 1. 2012-2015 оны байдлаар ачсан вагоны тоо / сараар /

Cap	2012 он	2013 он	2014 он	2015 он
1	194	228	170	100
2	116	95	70	76
3	265	262	334	439
4	303	403	301	955
5	351	360	291	946
6	442	463	301	921
7	534	511	450	989
8	649	329	652	1062
9	600	358	451	946
10	379	436	231	647
11	305	319	132	154
12	307	117	156	134
Дүн	4,445	3,881	3,539	7,369

График 1. 2012-2015 оны ачилт, буултыг харьцуулсан үзүүлэлт / жилээр /



Хүснэгт 4. Орлогыг нэр төрлөөр харуулсан нь/мян төгрөг /

Д/д	Орлогын төрөл	2014 он	2015 он	Зөрүү	Өсөлт бууралт /хувиар/
1	Ачилтын орлого	4,560,723.5	8,175,370.2	3,614,646.7	44.2%
2	Буултын орлого	36,423.0	20,731.0	-15,692.0	-43%
3	Агуулах хадгалалт гарах хуудасны бусад орлого	493,271.9	247 960,9	-245,311.0	-49.7%
4	Бусад орлого	306,861.1	119,169.9	-187,695.2	-61.2%
	Нийт орлого	5,397,279.5	8,563,228.0	3,165,948.5	36,9%

Хүснэгт 5. Гаалийн хяналтын бүсэд гаалийн бүрдүүлэлт хийхээр нэвтэрсэн машины тоо, хураамж

Cap	Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл		Хяналтын бүс болон агуулахад ачаа бараа хадгалсны хураамж
	Toо	Хураамж	Мөнгөн дүн
1 cap	315	1 431 818	13 481 750
2 cap	122	554 545	12 628 282
3 cap	351	1 595 455	20 913 083
4 cap	545	2 477 273	30 680 975
5 cap	782	3 55 4454	19 167 000
6 cap	740	3 363 636	25 398 723
7 cap	641	2 913 636	16 013 250
8 cap	751	3 413 636	14 370 600
9 cap	770	3 500 000	27 661 887
10 cap	512	2 327 273	16 570 200
11 cap	338	1 536 364	6 793 000
12 cap	255	1 159 091	9 800 525
Нийт дүн	6 122	27 827 273	231 479 275

Гаалийн баталгаат агуулахын үйлчилгээ

Тус компани нь 2010 оноос хэрэгжүүлсэн терминаль барьж байгуулах төсөлдөө 2-3 агуулах барихаар төлөвлөсний дагуу 1200м² талбайтай 1 агуулах, 1500м² талбайтай 2 агуулахыг 2010-2012 оны хооронд барьж ашиглалтанд оруулсан бөгөөд эдгээр агуулахуудаас 2 агуулахыг нээлттэй гаалийн баталгаат агуулахын зорилгоор ашиглахаар Гаалийн ерөнхий газраас зөвшөөрлөө авсан. 2015 оны байдлаар 26 төрлийн, 213,479.3 /мянган/ төгрөгийн материал, тоног төхөөрөмж хадгалуулсан байна.

5. Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан


Манай компани нь одоо үйл ажиллагаа явуулж байгаа сум орон нутагтаа дээгүүр байр эзлэх татвар төлөгч байгууллага билээ. Үүнийг ч Үндэсний татварын алба, Замын-Үүд дэх татварын хэлтсээс өндөр үнэлж 2014 онд Шилдэг татвар төлөгч байгууллага буюу Татварын албаны дээд шагнал хөх дэвтэр эзэмшигч байгууллагаар Дорнговь аймгаас 3 аж ахуйн нэгжийг шагнасаны нэг нь тус компани шалгарч шагналаа гардаж авлаа.

Зураг 9. Шагнал гардаж авлаа



Татварын алба, нийгмийн даатгалд тушаасан татвар, шимтгэлийг төрөл, хэмжээгээр нь харуулвал:

График 3. Нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэл



Хүснэгт 6. Татвар төлөлт

д/д	Огноо	Суутган татвар / ХХОАТ /	Орлогын татвар
1	2012	9,678,791.00	12,302,365.00
2	2013	13,892,546.00	47,742,155.00
3	2014	16,472,167.00	114,913,973.00
4	2015	20,453,121.00	124,103,307.00
	Нийт орлого	60,496,625.00	299,061,800.00

6. Нийгмийн хариуцлагын тайлан

Замын-Үүд суманд үйл ажиллагаагаа явуулахад ажиллах хүчний тогтвортой суурьшилтуу шилжилт хөдөлгөөн их байдагтай холбоотойгоор ажлын тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөл байдал догондолжой байдаг нь ажилд сэргөөр нөлөөлдөг. Ажилчдын тогтвортой суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр түлхүү анхаарч ажиллаж шаардлагатай зээл тусламж авахад дэмжлэг үзүүлэх, нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярыг хамт олон, гэр бүлээрээ тэмдэглэх, спортын болон хөгжөөнт тоглоом, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Үүнээс гадна ажлын их ачаалал, ядралтыг тайлах зорилгоор жил бүр байгууллагынхаа ажилчдыг 3-7 хоног дотоод, гадаадын аялалыг зохион байгуулж хэвшсэн. Энэ онд Байгал нуур, Итгэлт хамбын хийдээр зэрэг түүхэн дурсгалт байгалийн үзэсгэлэн бүрдсэн газруудаар аялах аялалыг зохион байгуулж ирлээ.



II. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2.1 Компанийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт

Компанийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.

2.2 Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	Чулун овогтой Энхболд	ТУЗ-ийн дарга	Дээд	Э-Транс ХХК Ерөнхий захирал

2	Чулуун овогтой Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Э-Транс Логистикс ХК Гүйцэтгэх захирал
3	Санжмятав овогтой Отгонбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий менежер
4	Сэджав овогтой Санжаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Мэдээлэл Аудит ХХК, Мэргэжилтэн
5	Баярсайхан овогтой Пүрэвбаатар	ТУЗ-ийн гишүүн	Дээд	"Си Би Эм"ХХК, Санхүүгийн шинжээч
6	Бадан овогтой Батбаатар	ТУЗ-ийн гишүүн	Дээд	"Си Би Эм"ХХК, Гүйцэтгэх захирал
7	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	ТУЗ-ийн гишүүн	Дээд	БидиСек ХК Тэргүүн дэд захирал
8	Ариунболд овогтой Батболд	ТУЗ-ийн гишүүн	Дээд	"Оптимал проект"ХХК захирал
9	Халтар овогтой Батхишиг	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Нефть Ойл ХХК, Гүйцэтгэх захирал

2.3 Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл

№	Овог нэр	Цалин урамшууллын хэмжээ	Бусад	Эзэмшиж буй хувьцааны тоо
1	Чулуун овогтой Энхболд	0₮	ТУЗ-ийн дарга	Эзэмшдэггүй
2	Чулуун овогтой Амарсанаа	Сарын 1.000.000₮	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал	Эзэмшдэггүй
3	Санжмятав овогтой Отгонбаяр	0₮	ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй
4	Сэджав овогтой Санжаа	0₮	ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй
5	Баярсайхан овогтой Пүрэвбаатар	0₮	ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй
6	Бадан овогтой Батбаатар	0₮	ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй

7	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	0₮	ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй
8	Ариунболд овогтой Батболд	0₮	ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй
9	Халтар овогтой Батхишиг	0₮	ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй

2.4 ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод

	овог, нэр	Эрхэлдэг ажил	Эзэмшсэн мэргэжил, боловсрол	Эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь	Хараат бус гишүүн эсэх
1	Чулуун овогтой Энхболд	Э-Транс ХХК Ерөнхий захирал	Ленинградын Төмөр замын дээд сургууль, Төмөр замын инженер	Эзэмшдэггүй	Энгийн
2	Чулуун овогтой Амарсанаа	Э-Транс Ложистикс ХК Гүйцэтгэх захирал	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль, Уулын инженер	Эзэмшдэггүй	Энгийн
3	Санжмятав овогтой Отгонбаяр	Э-Транс ХХК, Ерөнхий менежер	Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Бизнесийн удирдлага	Эзэмшдэггүй	Энгийн
4	Сэджав овогтой Санжаа	Мэдээлэл Аудит ХХК, Мэргэжилтэн	Санхүү Эдийн Засгийн Техникум	Эзэмшдэггүй	Энгийн
5	Баярсайхан овогтой Пүрэвбаатар	"Си Би Эм"ХХК, Санхүүгийн шинжээч	University Tomas Bata in Zlin8 Czech Republiv, Business Administration	Эзэмшдэггүй	Энгийн
6	Бадан овогтой Батбаатар	"Си Би Эм"ХХК, Гүйцэтгэх захирал	The George Washington их сургууль, Бизнесийн удирдлага	Эзэмшдэггүй	Энгийн
7	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	БиДиСек ХК Тэргүүн дэд захирал	ШУТИС, Нефтийн инженер	Эзэмшдэггүй	Хараат бус
8	Ариунболд овогтой Батболд	"Оптимал проект"ХХК захирал	Санкт-Петербургийн төмөр замын дээд сургууль	Эзэмшдэггүй	Хараат бус
9	Халтар овогтой Батхишиг	Нефть Ойл ХХК, Гүйцэтгэх захирал	ШУТИС, Нефтийн инженер	Эзэмшдэггүй	Хараат бус

Компани нь 2014 оны 04 сарын 28-ны өдөр "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-ыг зарлан хуралдуулж, ТУЗ-ын гишүүдийг сонгосон бөгөөд 2014 оны 04 сарын 29-ний өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороог Б.Батбаатар, А.Батболд, Б.Лхагвадорж гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус Б.Лхагвадорж гишүүнийг томилсон.

- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороог Ч.Энхболд, С.Санжаа, Б.Лхагвадорж гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин, урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ч.Энхболдыг томилсон.
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог Ч.Энхболд, Х.Батхишиг, С.Санжаа гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ч.Энхболдыг томилсон.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2014 онд 4 удаа хуралдсан бөгөөд тогтоол шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.

2.5 Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан

Компанийн зүгээс үйлчлүүлэгчдийг татах, хурдан шуурхай үйлчилгээг хүргэх, үйлчлүүлэхэд таатай орчинг бүрдүүлэх, үйл ажиллагаагаа сурталчилан танилуулах зэрэг олон нийтийг хамарсан олон төрлийн уян хатан бодлого, сурталчилгаа явуулсан ба хамт олны зүгээс ч энэхүү бодлогыг дэмжин баг хамт олон болж гар нийлж ажилласны хүчинд 2015 онд өөрийн салбар замаас ачигдсан вагоны тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2 дахин өссөн.

Энэ өсөлтөнд УБТЗ-ын Замын-Үүд өртөөний удирдлага, манай компанийт хамтарч ажилладаг цэх, тасаг, албадын үйл ажиллагаа ихээхэн нөлөөлсөн бөгөөд тус компани нь Замын-Үүд өртөөний удирдлагатай байгуулсан салбар зам ашиглах гэрээний үүргийн дагуу аливаа асуудлыг яриа хэлэлцээрийн замаар шуурхай, оновчтой зохион байгуулж улирал бүр салбар зам эзэмших, ашиглах гэрээний дүнгийн хурлыг зохион байгуулан хийж гүйцэтгэсэн ажилдаа үнэлэлт дүгнэлт өгч байсан нь энэхүү амжилтанд хүрэх гол нөхцөл нь болж өгсөн гэж бид дүгнэдэг.

Д/д	Орлогын төрөл	2014 он	2015 он	Зөрүү	Өсөлт бууралт /хувиар/
1	Ачилтын орлого	4,560,723.5	8,175,370.2	3,614,646.7	44.2%
2	Буултын орлого	36,423.0	20,731.0	-15,692.0	-43%
3	Агуулах хадгалалт гарах хуудасны бусад орлого	493,271.9	247 960,9	-245,311.0	-49.7%
4	Бусад орлого	306,861.1	119,169.9	-187,695.2	-61.2%
	Нийт орлого	5,397,279.5	8,563,228.0	3,165,948.5	36,9%

2015 онд Улаанбаатар төмөр зам өөрийн замаар тээвэрлэх ачааны тээврийн хөлсийг ачааны нэр төрлөөс хамаарч 20-25%-иар нэмэгдүүлсэн нь манай компанийн хувьд ашиг орлогоо тооцвол үйлчилгээний тариф нэмэх зайлшгүй шаардлага гарсан. Гэхдээ манай компанийн удирдлагын баг тээврийн хөлсөө нэмэгдүүлэхийг урталь болгоогүй бөгөөд 1 вагон шилжүүлэн ачихаас олох ашгийг 2 вагон ачиж олохоор

тооцоо гарч байсан ч бид үйлчилгээний тарифаа нэмэгдүүлэлгүй Улаанбаатар төмөр замын үйлчилгээний тарифаас 20,000-30,000 төгрөгний хямд ачих болсон нь хэрэглэгчдийг татах нэгэн ажил болж ачилтын орлого 3 614 646,7 мянган төгрөгөөр нэмэгдэх нэг нөхцөл болсон.

2.6 Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн талаарх тайлан

Манай компани нь Монголын компанийн засаглалын кодексыг мөрдөн ажиллаж байгаа ба тухай бүр СЗХ, МХБ, өөрийн веб сайт, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр компанийн хувьцаа эзэмшигч, олон нийтэд компанийн мэдээллийг хүргэн ажиллаж байна.

III. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

3.1 Аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар тодруулга, дүгнэлт



“НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

оны ____ сарын ____ өдөр

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК -ийн хувьцаа эзэмшигчдээ

Бид Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайландаа аудит хийж гүйцэтгээ.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь компанийн Гүйцэтгэх удирдлагын хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад санхүүгийн ажил гүйлгээнд тохирох нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг сонгон авч хэрэглэх, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг үнэн зөв хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлийг агуулаагүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, энэхүү үйл явцтай холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх асуудал багтана.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн энэхүү санхүүгийн тайлангийн талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм.

Бид танай санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, Аудитын Олон улсын Стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомж, манай компанийн “Аудит хийх журам”-ыг баримтлан хийв. Аудит хийхдээ түүвэрлэсэн анхны баримтаас тайлан хүртэл хөөн шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, задлан шинжлэх, асууж ярилцах зэрэг аудитын горимуудыг ашиглав.


Бидний хийсэн аудит нь санхүүгийн тайлангийн талаар санал, дүгнэлтээ илэрхийлэх хангалттай үндэслэлийг бий болгосон гэдэгт итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр энэхүү санхүүгийн тайланы 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой үзүүлсэн байна.

Бусад

Энэ дүгнэлтийг өөр аливаа нэг этгээдэд биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан, тэдний хүсэлтээр хийсэн аудитад үндэслэн гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Э-Транс ложистикс

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

2015 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		2015 оны 01-р сарын 01	2015 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	21,211,719.54	90,754,968.17
1.1.2	Дансны авлага	37,215,710.00	23,716,200.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	2,452,791.69	3,692,299.12
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	72,317,204.44	70,057,209.73
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	1,032,418.00	
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
1.1.10	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	134,229,843.67	188,220,677.01
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,435,608,939.09	5,171,885,092.31
1.2.2	Биет бус хөрөнгө	880,677,613.42	845,357,461.75
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	3,834,128.91	1,062,012.70
1.2.7	Хөрөнгө оруулалтын үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,320,120,681.42	6,018,304,566.76
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,454,350,525.09	6,206,525,243.77
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	258,365,421.00	117,205,764.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	7,798,135.91	1,352,755.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	313,083,485.11	199,361,276.77
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Суутган татварын өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	ҮЛДЭГДЭЛ	
		2015 оны 01-р сарын 01	2015 оны 12-р сарын 31
2.1.1.12	Хойшлогдсон татварын өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	579,247,042.02	317,919,795.76
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	579,247,042.02	317,919,795.76
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн		
2.3.2	- хувийн	4,620,000,000.13	4,620,000,000.13
2.3.3	- Хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	154,000,000.00	154,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	823,000,000.00	774,858,080.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	278,103,482.94	339,747,367.87
2.3.10			
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	5,875,103,483.07	5,888,605,448.00
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	6,454,350,525.09	6,206,525,243.76

Ерөнхий захирал  (Ч.Амарсаннаа)

Ерөнхий нягтлан бодогч  (Э.Ариунтуяа)

Баталгаажуулсан:.....

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Э-Транс логистикс
(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

2015 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2015 оны 01-р сарын 01	2015 оны 01-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		8,444,062,065.45
2	Борлуулсан бүтээгдхүүний ортог		8,036,507,956.70
3	Нийт ашиг (алдагдал)		407,554,108.75
4	Түрээсийн орлого		45,927,272.73
5	Хүүний орлого		2,419,840.01
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		70,818,818.18
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал		347,760,203.85
11	Санхүүгийн зардал		48,339,805.22
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(17,213,595.53)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(331,636.36)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		(36,289,305.00)
18	Татвар толохийн омних ашиг (алдагдал)		76,785,493.71
19	Орлогын татварын зардал		15,141,608.78
20	Татварын дараах ашиг (алдагдал)		61,643,884.93
21	Зогсоосон ўйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		61,643,884.93
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал		
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		61,643,884.93
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Ерөнхий захирал _____ (Ч.Амарсанаа)
 Ерөнхий нягтлан бодогч _____ (Э.Ариунтуяа)
 Баталгаажуулсан:.....



МОНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН


Э-Транс логистикс

2015 оны 12 сарын 31

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2015 оны 01-р сарын 01	2015 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		8,626,441,486.60
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		8,603,649,812.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		3,248,067.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтын орлого		
	Бусад мөнгөн орлого		19,543,607.60
1.2	Мөнгөн зарлага (-)		8,275,287,629.61
	Ажиллагчдад төлсөн		250,892,654.90
	Нийтмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө		27,681,975.00
	Бараа материал худалдан авахад төлсөн		387,970,806.00
	Ашиглалтын зардалд төлсөн		65,571,834.00
	Түүш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		7,334,117,848.50
	Хүүний төлбөрт төлсөн		35,460,194.22
	Татварын байгууллагад төлсөн		124,103,307.68
	Даатгалын төлбөрт төлсөн		476,440.00
	Бусад мөнгөн зарлага		49,012,569.31
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		351,153,856.99
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		6,419,840.01
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		4,000,000.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		2,419,840.01
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Үндсэн хөрөнгө олж зээмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж зээмшихэд төлсон		
	Хөрөнгө оруулалт зээмшихэд төлсон		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж зээмшихэд төлсөн		
	Бусад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		6,419,840.01
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		25,870,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		25,870,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		313,900,448.38
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		313,900,448.38
	Санхүүгийн түрээсийн оглөйт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсон ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(288,030,448.38)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		69,543,248.62
5	Мөнгө, түүнтэй адилтхах хөрөнгийн эхний үлдээдэл		21,211,719.54
6	Мөнгө, түүнтэй адилтхах хөрөнгийн эцсийн үлдээдэл		90,754,968.17

Ерөнхий захирал  (Ч.Амарсанаа)

Ерөнхий нягтлан бодогч  (Э.Ариунтуяа)

Баталгаажуулсан: 

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Э-Транс логистикс
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр

2015 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээ	Галаад валют хөрүүлэлийн нөөц	Эзний өмчийн бусад хэсэг	Хурийтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2014 оны 1-р сарын 1-ийн үлдээлээ	4,620,000,000.13		154,000,000.00			823,000,000.00		5,597,000,000.13
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт								
Залруулсан үлдээлэл								
Тайлант үсийн цэвэр ашиг (салдагдал)								
Бусад дэлгэрэнгүй орлогото								
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг								
Дахин үнэлгээний нэмээлэл								
2015 оны 01-р сарын 01-ийн үлдээлээ	4,620,000,000.13		154,000,000.00			823,000,000.00		5,875,103,483.07
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт								
Залруулсан үлдээлэл								
Тайлант үсийн цэвэр ашиг (салдагдал)								
Бусад дэлгэрэнгүй орлогото								
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг								
Дахин үнэлгээний нэмээлэл								
2015 оны 12-р сарын 31-ийн үлдээл	4,620,000,000.13		154,000,000.00			774,858,080.00		5,888,605,448.00

Брөнхий захирал _____ (Ч.Амарсанаа)

Брөнхий нягтан бологч _____ (Э.Арчунтуяа)

Баталгаажуулсан:.....



3.2 Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

3.3 Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа

Компанийн өөрийн хөрөнгө/ хувь нийлүүлсэн хөрөнгө=1.27

3.4 Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаарх мэдээлэл

Компани нь тайлант жил зээл аваагүй бөгөөд 2011 оны 11 сард Хасбанкнаас авсан зээлээс 99.8 мянган ам.долларын зээлийн үлдэгдэлтэй байна.

IV. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

4.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр

Компани нь 2015 оны 04 сарын 28-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайландаа хийгдсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлан, хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөө
4. Компанийн аудитын хорооны тайлан
5. Компанийн дүрэмд өөрчлөх тухай
6. ТҮЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
7. ТҮЗ 2015 оны цалин урамшууллын төсөв батлах
8. Ногдол ашиг тараах эсэх

Компани нь 2014 оны 04 сарын 28-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2013 оны санхүүгийн тайлан, хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн аудитын хорооны тайлан
4. 2014 оны ажлын төлөвлөгөөг батлах
5. ТҮЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийг сонгох
6. ТҮЗ болон гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
7. Ногдол ашиг тараах эсэх

Компани нь 2013 оны 04 сарын 29-ний өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
2. Компанийн 2012 оны бизнес үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2013 оны бизнес төлөвлөгөөг батлах

4. Компанийн аудитын хорооны тайлан
5. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
6. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
7. Ногдол ашиг тараах эсэх

Компани нь 2012 оны 04 сарын 30-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
2. Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан, 2012 оны бизнес төлөвлөгөө
3. Хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах тухай
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга
5. Компанийн засаглалын 5 журам
6. ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох
7. ТУЗ-ийн зардлын төсвийг батлах
8. Бусад

4.2 Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Э-Транс ХХК	Ачаа тээврийн компани	50%
2	БиДиСек ХК	Брокер дилер, андеррайтерийн компани	15.72%
2	Монголиан Транспортэйшн Холдинг ХХК	Хөрөнгө оруулалтын сан, Люксенбургын вант улс	17.75%

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн болох Чулуун овогтой Энхболд, Санжмятав овогтой Отгонбаяр, Баярсайхан овогтой Пүрэвбаатар, Бадан овогтой Батбаатар, Бүрэнмэнд овогтой Лхагвадорж болон Гүйцэтгэх захирал Чулуун овогтой Амарсанаа нар компанийн хараат гишүүд болно.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн болох Ариунболд овогтой Батболд, Халтар овогтой Батхишиг, Сэджав овогтой Санжаа нар компанийн хараат бус гишүүд болно.

4.3 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл

Компани нь Э-Транс ХХК, Монголиан Транспортэйшн Холдинг ХХК, БиДиСек ХК гэсэн 5%-иас дээш хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчтэй бөгөөд 2015 онд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсэд өөрчлөлт ороогүй болно.

V. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

5.1 Компанийн тухайн жилийн ногдол ашгийн тухай

Компани нь өөрийн үйл ажиллагааг өргтөгтөх зорилгоор эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч Хас банкнаас зээл авсан ба зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан ногдол ашиг олгоогүй байна.